

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД  
ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙГ  
ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН МЭДЭЭ

/2019 оны нэгдүгээр улирлын байдлаар/

2019 оны 03 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн дагуу Нийтлэг үйлчилгээний газрын хэмжээнд өргөдөл гомдол шийдвэрлэлийг 2019 оны нэгдүгээр улиралд зохион байгуулсан ажлын тайланг хүргүүлж байна.

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Иргэд, аж ахуйн нэгжүүд болон ажилтан, албан хаагчдаас тайлант хугацаанд нийт 30 өргөдөл ирсэнийг [www.erp.ulaanbaatar.mn](http://www.erp.ulaanbaatar.mn) дотоод удирдлагын системд бүртгэн, холбогдох албан тушаалтанд программын тусламжтайгаар илгээн, 28 /93,33%/ өргөдлийн хариуг өгсөн, шийдвэрлэгдэх шатанд буюу хугацаа болоогүй 2 (6,67%) өргөдөл байна. Мөн хугацаанд хугацаа хэтэрч шийдвэрлэсэн болон хугацаа сунгаж шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй, шийдвэрлэлтийн явц болон системийн зохион байгуулалттай холбоотой зөрчил огт бүртгэгдээгүй болно.

Газрын хэмжээнд 2019 онд ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2,93 хоног байгаа нь 2018 оны мөн үеийнхтэй харьцуулбал 1 хоногоор, өргөдөл гомдлын хандалтын тоо 50,81 хувиар буурсан байгаа нь манай байгууллагын үйлчилгээ илүү түргэн шуурхай болж, үүссэн асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэж буйтай холбоотой гэж дүгнэж байна.

Хоёр. Өргөдөл гомдлын хандалтын мэдээ

Байгууллагад ирсэн өргөдөл гомдлыг хандалтын төрлөөр нь ангилвал:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл, хүсэлт – 3;
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл, хүсэлт – 5;
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл, хүсэлт – 12;
- Жирэмсний болон ээлжийн амралт хүссэн өргөдөл, хүсэлт – 4;
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл, хүсэлт – 5.

Өргөдөл гомдлын төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь үзүүлбэл:




Гурав. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг өмнөх үеүүдтэй харьцуулсан байдал

Д/д	Хугацаа	2018.01 улирал	2018.02 улирал	2018.03 улирал	2018.04 улирал	2019.01 улирал
Ерөнхий үзүүлэлт						
1	Шийдвэрлэлтийн дундаж хугацаа	3 хоног 14 цаг 21 минут	5 хоног 5 цаг 47 минут	4 хоног 20 цаг 05 минут	4 хоног 11 цаг 25 минут	2 хоног 23 цаг
2	Хандалтын тоо	61	60	63	52	30
3	Зөрчлийн үзүүлэлт	26	9	0	0	0
Өргөдөл гомдлын хандалтын төрөл						
4	Хөдөлмөрийн хөлсний тухай	11	11	5	8	3
5	Захиргааны чөлөө хүсэх тухай	14	12	18	13	5
6	Ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх тухай	16	19	22	15	12
7	Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай	2	3	2	4	-
8	Жирэмсний болон ээлжийн амралтын тухай	7	2	5	8	4
9	Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай	7	10	6	9	5
10	Ажлын сахилга хариуцлагын тухай	3	-	4	1	-
11	Бусад асуудлаар	1	3	1	1	-

Манай байгууллага нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам"-д нийцүүлэн ажилтан, албан хаагчид, иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг хуанлийн 10 хоног бүр хөтлөн ажиллаж байна.

Хянаж, танилцсан

Захиргаа, санхүүгийн  
хэлтсийн дарга



Ч.Шинэчимэг


Дотоод хяналт-шинжилгээ,  
үнэлгээний ажилтан



Т.Ийтгэл

Тайлан гаргасан

Хууль эрх зүй, тогтоол шийдвэрийн  
хэрэгжилт хариуцсан ажилтан



Э.Хоролдулам